



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2004 оны 7 сарын 29 өдөр

Дугаар 252

Улаанбаатар

Гадаадад суралцуулах тухай

Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2003 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн болон 2004 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын 2.6-г үндэслэн ТУШААХ нь:

1. Банзрагч овогтой Мэогадыг ХБНГУ-ын Людвигсбург хотын Төрийн захиргааны удирдлагын дээд сургуулийн магистрантурт төрийн захиргааны удирдлагын чиглэлээр, Доржсүрэн овогтой Амартүвшинг Англи улсын Шеффейлд Халлам их сургуулийн магистрантурт аялал жуулчлалын менежментийн чиглэлээр, Ганболд овогтой Мөнхчимэгийг Английн Кингстон их сургуулийн магистрантурт эм зүйн чиглэлээр 2004-2005 оны хичээлийн жилээс тус тус 2 жилийн хугацаагаар суралцуулсугай.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр тооцоо хийхийг Сургалтын тэрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиглахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Гадаадад суралцуулах тухай" Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2003 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 320 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай. 2009-2010 онд кодификаци хийгдэв



САЙД

*[Handwritten signature]*

А.ЦАНЖИД